



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/439

Арвайхээр

**Тендерийн гүйцэтгэгчийг сонгох,  
тендер хүчингүй болгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3, 30 дугаар зүйлийн 30.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 76 дугаар дүгнэлтийн дагуу Сургууль, цэцэрлэгийн барилгын их засвар /Өвөрхангай, Бат-Өлзий, Хужирт, Зүүнбаян-Улаан сум/ ажлын 2 дугаар багц, Бат-Өлзий сумын ЕБС-ийн засварыг 108996940 (нэг зуун найман сая есөн зуун ерэн зургаан мянга есөн зуун дөч), 3 дугаар багц Зүүнбаян-Улаан сумын цэцэрлэгийн засварыг (дөчин найман сая дөрвөн зуун тавин нэгэн мянга нэг зуун дөрөв) төгрөгөөр тус тус Орчлонтулга ХХК-иар тус тус гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгжүүд санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөх, хүчингүй болсон багцуудыг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100740